МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ
ЮНЕСКОГИЙН ДЭРГЭД СУУГАА БАЙНГЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР
ПАРИС ХОТ

Хүлэмжийн барилга, байгууламж, угсралтын
Ричел группын тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажилагааны хөтөлбөрийн 3.3-т Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газраас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран гадаадын ХХААХҮ-ийн салбарт үйлдвэр, тоног төхөөрөмж, үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийг танилцуулж байна.

Энэ удаа Францын хүлэмжийн барилга, байгууламж Richel группыг Та бүхэнд танилцуулж байна. Тус групп нь 1964 онд үүсгэн байгуулагдсан, Францын мэргэжилтнүүд, Европын нийлэг хүлэмжийн байгууламжаар тэргүүлэх үйлдвэрүүдтэй хамтран 50 гаруй жилийн хугацаанд хүлэмжийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Өнгөрсөн хугацаанд тус компани нь 2000 онд шинээр “SHELLTERALL” буюу нар, салхинаас хамгаалсан сүүдрэвч, 2004 онд VENLO загварын шилэн хүлэмжийг зохион бүтээж, 2007 оноос хүлэмжийн аж ахуйд хэрэглэгддэг техник, тоног төхөөрөмжийг дэлхийн улс орнуудад нийлүүлж байна.



Ричел групп нь нийт 300 гаруй ажилчидтай бөгөөд дэлхийн 95 улс оронд хүлэмжийн барилга байгууламж, тоног төхөөрөмж суурилуулах, техникийн болон удирдлагын менежментээр хангах бүх талын үйлчилгээг хамарсан 500 гаруй төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.



Тус компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг /https://richel-group.com/?s=&continents=cei-en&type_de_serres=0&metiers=0/ цахим хуудсаас авах боломжтой бөгөөд **хамтын ажиллагааны асуудлаар** Contact us | Richel Group (richel-group.com) болон Парис дахь ЭСЯ-ны info@ambassademongolie.fr хаяг руу цахим шуудан илгээнэ үү.